

ХЭЛНИЙ БҮТЭЦ ТОГТОЛЦООН ДАХЬ УТГА, ХЭЛБЭР ШҮТСЭН ЗАРИМ ҮЗЭГДЭЛ, МӨН ЧАНАР

Ц.Оюун, доктор, Sc.D, профессор,
НХУС-ийн монгол хэлний тэнхимийн зөвлөх профессор

Резюме: В рамках данной статьи рассмотрел языковой системный подход и некоторые явления которые поклонились к смыслу и форму в системе структуры языка, также его качество. Язык как другие явления, является системой, которая обладает целостное и частычное качество.

Языковая система является хорошо организованной системой, способной поддерживать качество ранга закона языка.

Подразделения в языковой системе определяет некоторое качество целостного разделения. И целостный раздел обладает особенностью, общем виде определяет качество всех уровней. Если исчезнут одна инфраструктура то потеряется целостное свойство данного термина и потеряется системное качество.

Языковые явления для того чтобы существовать и развивая совершенствоваться опирающиеся на смысл языка установить формирование. Смысловая сторона или глубокая структурная сторона языка имеет первичный характер, поверхностная структура или форма языка имеет вторичный характер. А логические значения языка более поклонит сторону смысла, то языковое множество более поклонит сторону структурного система языка или формирование. В данной статье рассмотрел этих двух особенностей.

Если посмотреть с философской точки зрения, терминология существующая одной науке и существует в другой науке. Некоторые терминологии и понятия существующих в лингвистике сравнивая с множеством математики, с логической терминологией логики можно описывать сравнивая по аналогичным свойствам.

С точки зрения логической причины язык и психология человека найдено выражение по закону и формам логики. Поэтому язык зависимый от логики и логики зависимая от языка.

Түлхүүр үг: Бүхэллэг ба хэсэглэг чанар, утга


шүтсэн чанар, хэлбэр шүтсэн чанар, хэлний олонлог, хэлний логик

Бүхэллэг чанар, нэгдлийг олж өөр хоорондоо утга-бүтцийн холбоо харилцаанд оршин байх хэлний элементүүдийн цогцыг хэлний тогтолцоо гэдэг. Тогтолцооны онолыг 1990-ээд оноос өмнө системийн онол хэмээн нэрлэсээр иржээ. Хэлний тогтолцоог ч мөн эртнээс судалж, хэлний үзэгдлийн дотоод тогтвортой холбоо, шүтэн барилдлагыг тодорхойлох оролдлого хийсээр ирсэн байна. 19, 20 дугаар зууны заагт организмын хувьслын онол, химийн элементийн үелэх хууль, харьцангуйн онол, атом, эгэл хэсгүүдийн бүтцийн онол зэрэг байгалийн ухааны том хууль, нээлтүүд гарсан нь тэр үеийн бүх шинжлэх ухаанд тогтолцоон хандлага ноёлоход хүргэсэн байдаг. Энэ хандлага системийн бүтцийн тухай шинжлэх ухааны ойлголтыг хүчтэй дэлгэрүүлэхэд хүчтэй нөлөөлж, хэл шинжлэлд ч мөн хэлний бүтэц тогтолцооны онолын судалгаа нэвтэрч, Фернанд де Соссюр-ийн хэлний системийн “Хэл бол бүх элемент нь нэгэн бүхэл бүтэн зүйлийг бий болгодог систем, систем бол нэгдмэл чанар”, “Системд багтаж байгаа элементүүдийн үүрэг нь тэдгээр хоорондын харьцаагаар тодорхойлогдоно” гэсэн онолууд гарснаар эдүгээх хэлний тогтолцооны онолын суурь тавигджээ. Гэхдээ хэлний тогтолцооны онолын эх, сэтгэлгээ бүр эртнээс, тухайлбал, Аристотель, Платон “Мэдлэгийн тогтолцоо”-г илрүүлэх оролдлого хийж, Кант, Гегель нар “Танин мэдэхүйн тогтолцоо”-ны онол гаргаж ирсэн тэр үеэс үндэс нь соёолсон гэж үздэг.

Хэлний тогтолцоо нь, хэлний зүй тогтлын мөн чанарыг эрэмбэлэн хадгалж чадсан нарийн зохион байгуулалт бүхий цогц, бүхэллэг зүйл мөн. Аль ч улс үндэстний хэл хоорондоо нарийн зүй тогтлоор холбогдсон, тодорхой тооны, багталцаат нэгж хэсгүүдээс бүрддэг бүхэл бүтэн тогтолцоо билээ. Энэ учраас хэлзүйн байгууллыг:

- Бүхэллэг ба хэсэглэг чанар,
- Тэдгээрийн холбоо гэсэн уялдаагаар авч үздэг.

Үүнийг өгүүлбэр зүйн нэгэн хэсгийн тогтолцоогоор жишиглэн авч үзье.



Дээрх тогтолцоог үзвэл, хэлний бүхэллэгийг бүрдүүлэгч дэд нэгжүүд хоорондоо нягт холбогдсоны дээр, дээд эрэмбийн нэгж нь доод эрэмбийн нэгжээс бүрдэх шаталсан, багтаамал зарчимтай нь харагдаж байна.

Хэлний тогтолцоон дахь дэд нэгж нь буюу бүхэллэг нэгжийн зарим чанарыг тодорхойгоор илтгэдэг бол бүхэллэг нэгж нь бүх түвшний чанарыг ерөнхийлөн тодорхойлж байдаг онцлогтой. Эдгээр эрэмбэт бүтцийн аль нэг дэд бүтэц алга болчихвол уг ухагдахууны бүрэн бүтэн шинж алдагдаж тогтолцоот чанараа алдахад хүрнэ.

Тогтолцоон дахь их бага бүх нэгж харилцан логик уялдаатайн дээр тус тусын онцлогтой тул уг түвшдийг хооронд нь хольж хутгаж болохгүй, нарийн эрэмбэ бүхий юм.

Хэлний тогтолцоот шинжийн нэг онцлог нь түүнийг цөм агуулга, ухагдахуунд нь төвлөрүүлэн (ерөнхийлөн) хураангуйлж, эсвэл дэд ухагдахуунт тогтолцоогоор нь задлан тодорхой болгон дэлгэрүүлж авч үзэж болдог. Энэ нь хэлний нэгжид хийх индукц-дедукц шинжлэл мөн. Тэрчлэн тогтолцоон ухагдахуунуудыг эсрэг тэсрэг буюу төсөөт шинжээр нь хэсэглэн багцалж, нэгжүүдийг бүлэглэн томсгох (интеграцичлах) зэргээр бүтэцжүүлэн авч үзэж болдог. Энэ тохиолдолд тогтолцоон утга ихэсгэл ба багасгалын төсөөллөөрөө уян хатан, уялдаат шинжтэй байна. Энэ шинжийг хэлний дидактикт ашиглан модульжсан сургалт явуулж болно.

Хэлийг тогтолцоон дунд нь барьж байдаг чухал хүчин зүйл бол тодорхой орон зай, цаг хугацаа, хөдөлгөөнд нь зангидсан хэлний үзэгдлийн тогтоц, харилцан үйлчлэл юм. Үүнийг хэл шинжлэлд хэлний элементүүдийн бие биегүйгээр оршин тогтнодоггүй атлаа хоорондоо эсрэгцэх, нэгдэх, сэлгэх, нэгийгээ

нөхөх, төлөөлөх зэрэг харилцан хамааралт зүй тогтол гэж үзсээр ирсэн.

Хэлний тогтолцоог зориуд зохион байгуулж, зохиож болдоггүй, харин тогтолцоот зүй тогтлыг нь нээж илрүүлж байдаг. Хэлний тогтолцоо зүй тогтолдоо тулгуурладаг, зүй тогтол нь хэлний үзэгдлийн хувьсал, эрэмбэ, тогтоц зэргийг илэрхийлэн тодорхойлох ажээ. Хэлний зүй тогтол бол өөрийн гэсэн зүй тогтол, хуультай, уян хатан атлаа бас хатуу журамламал юм.

Хэлний их бага нэгж бүр дотроо бүтэцжсэн хүрээтэй, хүрээ бүр тогтолцоотой байдаг.

Хэл шинжлэлч А.А. Леонтьев “Хэл бол гадаад дотоод олон янзын хүчин зүйлийн дотор байнгын хөдөлгөөнд өөрчлөлттэйгээр оршин тогтнож байдаг. Гэтэл хэл, энэ их урт удаан хугацаан дахь олон хүчин зүйлийн дотор нөгөө л нэгдлээ хадгалсаар байдаг. Хэрэв хэл нэгдлээ эс хадгалбал харилцааны үүргээ, тэмдэглэх үүргээ алдана гэсэн үг” гэж бүтээлдээ тэмдэглэсэн нь бидний дээр өгүүлсэнд нийцнэ. Ер нь хэл цуваа цагийн үүднээс хөдлөгөөнтэй ч хам цагийн үүднээс харьцангуй тогтонги шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хэлний зүй тогтол тогтолцоот шинжээ хам цагт үндсэн шинжээр нь, цуваа цагт бага зэрэг чанарын хувьсалтайгаар хадгалж байдаг гэж хэлж болно.

Хэлний хөгжил нь хэлний үзэгдлүүдийн хөгжил, хэлний үзэгдлүүдийн харилцан үйлчлэл, харилцан нөхцөлдсөн байдал, тэдгээрийн холбоо нэгдлийн тухай хөгжлийн түгээмэл зарчимд тулгуурладаг. Энэ нь хэлний тогтолцоонд орших нэг үзэгдэл хөгжил хөдөлгөөний үр дүнд нөгөө үзэгдлээ бий болгож, нэг хэлбэр нөгөө хэлбэртээ шилжин байдаг үйл явц бөгөөд энэ өөрчлөлт хэлний тогтолцоот шинжээ хадгалсан учир

бүхий зүй тогтлын дотор явагдана.

Хэлний үзэгдлийн дээрх ялгаралт шинжүүд үгүйсгэгддэггүй, харин ч аккомадаци шинжийг агуулж уг нэгж бүхэллэг тогтолцоондоо оршин байх шинжийг нь тодосгож байдаг.

Ийн үзвэл, хэл нь өөрийн хөгжлийн хуультай, тодорхой зүй тогтол бүхий тогтолцоо юм.

Хэлний үзэгдэл оршин тогтнож, хөгжин боловсрохдоо хэлний утгыг түшиж хэлбэршлээ тогтоож байдаг байна. Утга тал нь буюу хэлний гүн бүтцийн тал (рема) анхдагч, хэлний өнгөн бүтэц (тема) болох хэлбэр нь хоёрдогч шатлал мэт ажиглагддаг. Харин хэлний логик нь утга талаасаа түлхүү шүтэх бол, хэлний олонлог ахуй нь хэлний бүтэц тогтолцоо буюу хэлбэршил талаа илүүтэй шүтэн оршдог. Энэ талаар доор өгүүлэе.

Нэг. Бүтэц тогтолцоо, хэлбэр шүтсэн хэлний олонлог

Гүн ухаан бүх шинжлэх ухааны үндсийн үндсийг талбарлаж байдаг. Энэ утгаар гүн ухааны тайллаар, нэг шинжлэх ухаанд байдаг ухагдахуун бусад шинжлэх ухаанд мөн байх ажээ.

Тухайлбал, физик, техник технологийн салбарт анх бий болсон “тогтолцоо” хэмээх ухагдахуун өдгөө хэл шинжлэл хийгээд бусад шинжлэх ухаанд хэрэглэгддэг бол олон улсын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд өргөн хэрэглэгддэг “интеграц” хэмээх ойлголт тодорхой шинжлэх ухаануудын дидактикт, үйлдвэрлэл, техник технологийн салбарт байдаг “технологи” гэдэг ухагдахуун сурган хүмүүжүүлэх ухааны салбарт нэвтрэн, түгээмэл хэрэглэгдэх болжээ. Энэ мэт шилжимхий ухагдахуун, ойлголтын учир шалтгааныг XX зууны үед үүсч хөгжсөн сциентизмийн гүн ухаан “Байгалийн шинжлэх ухааны ойлголт, үзэгдэл нийгмийн шинжлэх ухаанд мөн байдаг” хэмээн тайлбарласан байдаг.

Эл үзлийн үүднээс хэл шинжлэлд байдаг зарим ухагдахуун, ойлголтыг энэ удаа математикийн шинжлэх ухаанд байдаг хэд хэдэн ойлголт ухагдахуунтай адилсган харьцуулж, ижил төстэй шинжээр нь дүйлгэн тайлбарлаж байна. Эдгээрээс энэ өгүүллийн хүрээнд зөвхөн хэлний олонлогийн тухай ойлголтыг хэлний тогтолцоот зүй тогтлын үүднээс авч үзье.

Хэлний олонлог хэмээх ай (категори)-г математикийн олонлог хэмээх айтай бүтэц, бүрэлдэхүүн, оршин тогтнох зүй тогтол,

тогтолцоон үндэслэлээрээ тохирч буйг логикийн шинжлэх ухааны эх үүсвэрүүдээс харсан билээ. Өмнө өгүүлсэн тогтолцооны онолын ба хөгжил, хөдөлгөөн, харилцан үйлчлэлийн зүй тогтлын үүднээс авч үзвэл, үзэгдэл хоорондын холбоо, тогтоц янз бүрийн шинжтэй хэсэг, түвшин бүр хоорондоо харилцан шүтэлцсэн, харилцан үйлчилсэн шинжтэй байдаг.

Энэ холбоо, харилцан үйлчлэлийн үр дүнд хэлний нэг үзэгдэл нөгөө үзэгдлээ, хэлний нэг хэлбэр нөгөө хэлбэрээ, хэлний нэг хөдөлгөөн нөгөө хөдөлгөөнөө бий болгож байдаг ажээ. Жишээлбэл, эртний монгол хэлний “i”-авиа өөрөө түүхэн явцад ихэд хувьсан өөрчлөгдсөн эгшиг төдийгүй орчныхоо гийгүүлэгчдийг өөр гийгүүлэгч болгож, эр эгшгийг эм эгшиг болгодог “di”, “ti”-нь I –ийн нөлөөгөөр “j,č”-г үүсгэж улмаар I өөрөө “a, u”-гэх мэтээр олон хувиралд орсон нь бий. Энэ нь I –ийн хувьсалт хамаарлын бичил тогтолцоог бий болгосон ба эрт, эдүгээ, ирээдүйн гурван цагийн холбоонд оршино.

Энэ мэт хэлний зүй тогтолт үзэгдэл бүхэн нэгэн анги буюу нэгж-бүхэллэгийн; үндсэн – үндсэн бусын; анхдагч хэлбэр шинж-үүсмэл хэлбэр, шинжийн хамааралт тогтолцоог тус тус үүсгэдэг. Иймд хэлний тогтолцоог зөвхөн их, бага, дээд, доод гэсэн багталцаат шинжээр нь бус бас дээрх *анхны ба төгсгөлийн, үүсмэл ба үүсмэл бус шинж* тогтцоор нь тогтолцоот ойлголт болгон авч үзэж болох юм. Анхны хэлбэр бүтэц, утга нь дараах үеийнхээ хэлбэр бүтэц, агуулгад мөн багтаж байдаг. Хэрэв ингэж үзвэл, үүсмэл бусын үндсэн шинж үүсмэлийн үндсэн шинжид давхарлан шингэж багтана. Энэ утгаараа багталцаат шинжтэй гэж үзэх үндэслэлтэй юм.

Хэлний тогтолцоонд их, бага, зах-төвийн нэгж ухагдахуун багтдаг бол түүнд дүйцэх олонлог, дэд олонлогийн ухагдахуун мөн харгалзаж байдаг. Жишээлбэл, хэлний захын их нэгж нь хэлний олонлогийг бүрдүүлж байхад төвийн ба завсрын, захын ба доод нэгж нь тус тус хэлний дэд олонлогийг бүрдүүлдэг.

Ер нь, логик ухагдахуунаар олонлог гэдэг нь ерөнхий шинж тэмдгээрээ ижил төсөөтэй юмс үзэгдлийг хэлдэг. Энэ мэтээс үзвэл, хэлний олонлог үй олон юм. Жишээ нь, эгшгийн тогтолцоо бол эгшгийн олонлог. Өгүүлэхийн эрхтэний саадгүй хэлэгдэх байдлаараа ижил төсөөтэй тул нэг тогтолцоог үүсгэж олонлог болж байгаа юм. Гэтэл а, е, i, o, u, ò, ú нь эгшиг гэсэн тогтолцоонд багтаж дэд олонлогуудыг

үүсгэнэ. “а” гэсэн дэд олонлог нь дотроо бас “а, á, â, ã, ä, å” гэх мэт дэдийн дэд олонлогийг үүсгэх жишээтэй байна.

Тогтолцооны онолд дэд эрэмбүүд үндсэн эрэмбийн тодорхой шинжийг хадгалж, үндсэн эрэмбэ нь бүх тодорхой эрэмбийн цогц шинжийг ерөнхийлөн хадгалж байдаг.

Гэтэл хэлний олонлог нь тодорхой дэд олонлогуудын бүхэллэг үндсэн шинжийг, тодорхой дэд олонлог нь бүхэллэг үндсэн олонлогийн тодорхой хэсэг нь болж тусгай шинжийг хадгалж байна. Жишээлбэл, хэлний

толь бичиг гэдэг олонлог буюу их нэгж дэд олонлог буюу үгсийг тольчлон тайлбарладаг утга, үүргээрээ ижил олон төрлийн толийг багтаадаг. Энэ нь өвөрмөц гурван эрэмбэт тогтолцоог үүсгэнэ.



Хэлний олонлог нь уг олонлогийн элементүүдээс бүрдэнэ. Жишээ нь, хэлний толь бичиг гэдэг захын их нэгж болох олонлогийн дэд элементүүд нь нэг хэлний, олон хэлний толь бичиг гэх завсрын дунд нэгж болон мөн түүнд багтах зөв бичгийн толь бичиг, тонгоруу толь бичиг, зүйл хуваасан толь бичиг, орчуулгын толь бичиг, хэлц үгийн толь бичиг гэх захын бага нэгжүүдээс бүрдэж байна.

Эдгээр элемент “үгийг тодорхой буюу бүлэг шинжээр нь тайлбарладаг” гэдэг шинжээрээ нэгдмэл, тус тусын өөр бүлэглэл зориулалттай гэдгээрээ тусгаар дэд элемент бүхий дэд олонлогууд юм. Бүр тодруулбал, С-1, С-2, С-3, С-4, С-5, С-6, С-7, С-8 гэсэн захын бага, дэд олонлог нь хэлний толь бичиг А, Б гэх завсрын дунд олонлогт багтах элемент байгааг бид дээрх зураглалаас харж байна.

Математик, логикийн шинжлэх ухаанд олонлогийг үлэмж (универсаль) олонлог, нэгж олонлог, тэг буюу хоосон олонлог гэж ангилдаг бөгөөд ганц элементээс бүрдэж байвал нэгж олонлог, нэг ч элементийг агуулаагүй бол тэг буюу хоосон олонлог болдог. Дээрх жишээн дээр буулган авч үзвэл, үлэмж олонлог нь толь бичиг, нэгж олонлог нь нэг хэлний толь бичиг (монгол

хэлэнд хамааралтай гэж үзэх тул) юм.

Үгийн бүтцээр жишиглэн үзвэл, тэг ба хоосон олонлог нь тэг бүтэврүүд буюу түүн доторх нэрлэхийн тийн ялгалын далд бүтэвэр байж болох жишээтэй. Хэлний тэг буюу хоосон олонлог хязгаартай цөөн тохиолддог. Логикийн ухаанд нэгж олонлогт нар, сарыг, тэг буюу хоосон олонлогт бут, бурхан мэт ухагдахууныг багтаасан байдаг. Ер нь хэлний утга, бүтэц тогтолцоо шүтсэн олонлогийн асуудлыг нарийвчлан судалбал сонирхолтой баримт нэлээд гарч ирэх юм.

Хоёр. Утга шүтсэн хэлний логик

Хүний хэл сэтгэхүй нь агуулга, учир шалтгаанаас нэгэнт ангид бус тул тэр бүхэн логикийн хуулиудад зохилдож, логикийн хэлбэрүүдээр илрэлээ олж байлдаг. Ингэхээр хэл ч логик хамааралтай, логик ч хэлний хамааралтай. Энэ нь хэл, сэтгэхүй, логикийн гурвалж үүсгэж, оюун ухааны пирамид болж байдаг.

Логикийн ухааны гол ухагдахуун болох ойлголт нь хэлний утгат нэгж болох үгийн утгатай, логикийн бодомж нь хэлний дэлгэрэнгүй нэрлэх нэгж болох өгүүлбэрийн утгатай дүйж холбогдох жишээтэй. Мөн хэлний зүй тогтол,

хэл зүйн баталгаа нотолгоо бүгд л логикийн үндсэн хуулиудад тулгуурлаж байдаг. Жишээ нь, хэлний үзэгдлүүдийн мөн чанар, утга, үүрэг, харьцаа, хамаарал, онцлог, ялгааг гаргахад адилтгалынхууль, зөрчилгүйнхууль, үгүйсгэлийн ба хангалттай үндэслэлийн хууль зэрэг логик хуулиудыг үндсэнд нь баимталдаг. Иймд бид хэлний логик шинжийг тодорхойлохдоо, хэлний үзэгдлүүдийн шалтгаант холбоог тогтоох логик арга болох ерөнхийлэх, тусгайлах харилцаа хийгээд аналог оюун дүгнэлтийн аргыг хэл шинжлэлийн усдалгааны арга зүйд өргөн хэрэглэх нь чухал.

Хэл логик хоёрыг алхам тутамд холбож байдаг хамгийн нийтлэг үзэгдэл нь логикийн ойлголт, логикийн бодомж хоёр тул энэ өгүүллийн хүрээнд зөвхөн энэ тухай авч үзье.

Ойлголт нь сэтгэхүйн хэлбэр бөгөөд тэр нь хэлний гүн бүтцийг өнгөн бүтэц болгох нэг буюу хэд хэдэн үг, өгүүлбэрээр илэрдэг, бодит байдлыг хийсвэрээр сэтгэжтанин мэдэх нэг хэлбэр юм. Ойлголт нь хүн уг юмыг хамгийн цөм, гол шинжээр нь ухаж, ерөнхийлэн нэгтгэсэн үр дүн байдаг. Жишээ нь, бага ангийн хүүхэд “үг”-ийн тухай ойлголтыг үг үгээр үглэн хэлдэг учраас, өгүүлбэрийг харин өгүүлэн хэлэх учраас л ингэж нэрлэсэн байх гэсэн урьдчилсан төсөөлөлтэй байж болох. Тэгвэл энэ нь түүний шинжлэх ухааны мэдээлэл авахын өмнөх, өөрийн нь хийсвэрлэж бүтээсэн ойлголт байх жишээтэй. Төсөөлөл хэлний гүн бүтцийн гадаад талыг тусгадаг бол ойлголт дотоод мөн чанар хийгээд гол шинжийг тусгадаг. Гэтэл хүүхэд гадаад, дотоод шинж байдлыг нэг ижил байдлаар өнгөц тусгаж болох талтай.

Сэтгэгдэж байгаа юм үзэгдлийн гол гол шинж тэмдгийн цогцос нийлбэрийг ойлголтын агуулга гэж логикт үздэг нь хэл шинжлэлийн бүрэлдвэр болох хэлний бүх үзэгдлийн мөн чанар, утга агуулгын тодорхойлолтод мөн баригдсаар ирсэн зүйл юм.

Ойлголтын зөв буруу шинж нь утга агуулга, үг сонголт, найруулга, баймж зэргээс ихээхэн шалтгаална. Мөн ойролцоо утгат үг, өгүүлбэр үндсэндээ нэг ойлголтод хүргэж болдог бол утга өөр ижил нэр, эсрэг утгатай үгс тийм биш. Бас ойролцоо утгат төсөө үгийг өгүүлбэрт хэрэглэхдээ онож сонгоогүйгээс буруу ташаа ойлголтод хүргэж болно. Яг оносон тохиолдолд мөн тэр хэмжээгээрээ оновчтой ойлголтод хүрдэг. Жишээ нь, “...Үүдэн шүд чинь унаад ирэхийн цаг дээр үзэж харах ч хүнгүй

болно оо Сүнжидмаа минь...” гэсэн өгүүбэрт “үзэж харах” гэдэг “ухаарлыг” нээх ёстой болж байгаа юм. Иймд явж явж үгийн утга, үг сонголт, хүнд буух ойлголт, түүний зөв буруу шинж зэрэг нь хоорондоо шууд хамааралтай болох тул хэл логик хоёр нь ойлголтод тулгуурласан нэгсмэл үр дүнг үзүүлж байгааг бид харж байна.

Логикт, бодис юмс, үзэгдэл, байдлын төсөөтэй ба ялгаат шинжийг тогтооход туслах аргыг “жишилт” гэж нэрлэдэг. Энэ аргыг хэл шинжлэлд хэлний үзэгдлийн хувь онцлог, ялгааг илрүүлэн тогтооход хэрэглэх нь бий. Жишээ нь, “Нэрлэхийн тийн ялгал бол тийн ялгал мөн” гэдгийг батлахын тулд нэрлэхийн тийн ялгалыг тийн ялгал гэдэг категорт байдаг шинжүүдээр жишин үзэж байж мөн гэдгийг нь нотолдог. Тэгэхээр логик аргууд хэл шинжлэлд түүний шинжлэх ухаанч баталгаа нотолгоо хийх нэг ёсны гол арга, нөгөө талаар хэлний үзэгдлийн дотоод мөн чанарыг илрүүлэх чухал хэрэглүүр нь байх юм.

Хэлний үзэгдэл, нэгж ухагдахуунуудын тухай ойлголтыг буй болгож, тэдгээрийн түгээмэл зүй тогтол ба гол шинжийг ялгаруулахад дээр дурдсан логик жишилтээс гадна анализ, синтез (задлаг, нийлэг), хийсвэрлэл, ерөнхийлөл зэрэг олон логик арга бий бөгөөд тэдгээрийг ч мөн хэл шинжлэлд хэрэглэсээр ирсэн уламжлал бий.

Логикийн бодомж хэмээх чухал ухагдахуун нь хүний сэтгэхүйн нэг хэлбэр болохын сацуу хэлний үзэгдлүүдийн хоорондын холбоо хамаарал, тэдгээрийн оршин буй эсэхийг нотлох, үгүйсгэх үйл дээр биежиж байдаг хэлбэр мөн. Энэ утгаараа бодомжийн ухагдахуун сэтгэл судлал, логик, хэл шинжлэлийн зааг дээрх асуудал болдог учиртай. Өнөө үед асуудлыг шинжлэх ухаан хоорондын уялдаагаар тайлбарлах, дискурс утгаар авч үзэх хандлага чухалчлагдах болсон тул логик, сэтгэц хэл шинжлэлийн асуудал хүмүүсийн сонирхлыг татаж, судлаачдын анхаарлын төвд байх нээлттэй асуудал болсон байна.

Аливаа хэлний бодомж танин мэдэхүйн ижил үүрэгтэй предикат хэрэг, субъектийн бүтэцтэй байдгийг бид мэддэг. Энэ хоёр нь өгүүлбэрийн бүтцэд бүр ч тод илэрдэг бөгөөд бодомж, өгүүлбэр хоёр дотоод бүрэлдэхүүнээрээ харилцан ялгаатай юм. Жишээ нь, арван тавны сар нь агаар тэнгэртээ дэнлүү гэдэг өгүүлбэрийн бодомжид арван тавны сар гэдэг ойлголт нь субъект, агаар тэнгэртээ дэнлүү гэх ойлголт нь предикат болно. Гэтэл энэ өгүүлбэрийн

өгүүлэгдэхүүн сар, өгүүлэхүүн нь дэнлүү гэсэн үг болно. Дээрх бодомж өгүүлбэрээр илэрч буй хэдий ч бодомж бүхэн өгүүлбэр байдаггүй. Энэ дууны шүлгийг хэн зохиосон бэ? гэдэг өгүүлбэр бодомж биш. Учир нь бодомж бүр баталж нотолсон, эсвэл үгүйсгэсэн өгүүлэмжтэй байх ёстой байдаг. Хүүрнэх, захирах утгатай өгүүлбэрүүд илэрхий бодомж бүхий байхад асуух, анхааруулах өгүүлбэр ил бодомжийг агуулж чадахгүй, харин далд буюу тэг бодомжид тулгуурласан байх жишээтэй. Үүнийг бодомж биш гэж үзэх нь ч бий. Жишээ нь, Чи одоо хүртэл яваагүй л байна уу? гэсэн өгүүлбэрт “Чи өдийд явчихсан л байх ёстой” бодомж санааг тэг байдлаар хадгалж байгаа. Энэчлэн өгүүлбэр зүйн ухагдахуунд утга талын маш их логик бодомж илэрч байдаг байна.

ДҮГНЭЛТ

Хэлний зүй тогтол нь дотоод чанар болох агуулгын ойлголт, бодомж логик, учир зүйн шинжлэх ухаантай нягт холбогдох тул эдгээр ухагдахууныг шат шатны хэлний сургалтын танин мэдэх үйлд алхамчлан суулгаж байвал зохино.

Бид өгүүлийнхээ эхэнд хэлний учир зүйн баталгаа нотолгоо, няцаалт хийх арга зүй логикийн хуулинд тулгуурладаг гэж хэлсэн билээ. Зөвхөн логикийн агуулга, ойлголт, бодомжтой холбож үзэхэд хэлний логик тал ийм өргөн агуулгатай юм.

Хэлний бүтэц тогтолцоо нь өөрийн гэсэн жам хууль, зүй тогтолтойн дээр түүний доторх хэлний үзэгдлүүдийн утга шүтсэн логик, бүтэц хэлбэрийг түлхүү шүтсэн олонлог мэт ийм сонирхолтой мөн чанар үй олон байгаа нь судлууртай, анхаарал татсан судалбар болоод байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дагдан, А., Дагвадорж, А., Доржпалам, Н. (1995). *Гүн ухааны товчоо*. Улаанбаатар
- Лувсанвандан, Ш. (1981). *Монгол хэл шинжлэлийн асуудлууд*. Улаанбаатар
- Леонтьев, А. А. (2010). *Психоллингвистические единицы и порождение речевого высказывания*. Москва
- Норовсамбуу, С. (1999). *Логик*. Улаанбаатар
- Оюун, Ц., (2004). Хэл шинжлэлийн өгүүллүүд,

УБ.

- Оюун, Ц., (1998, 20015). Зөв бичгийн дүрмийн тогтолцоот хураамж, УБ.
- Оюун, Ц., (2002). Монгол хэлний дидактик, түүнийг оновчлох нь, нэг сэдэвт зохиол, УБ.
- Өнөрбаян, Ц., (1994). Орчин цагийн монгол хэлний үг зүй, УБ.
- Пагва, Т., (2001). Ерөнхий хэл шинжлэлийн асуудлууд, дэд дэвтэр, УБ.
- Пүрэв Очир, Б., (1997). Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй, 1 дүгээр дэвтэр, УБ.
- Санжаа, Ж, (1997). Орчин цагийн монгол хэлний авиа зүй, УБ.
- Шилейко, А, М, Кочнев, М, Ф., (1985). Введение в информационную теорию систем, М.